


# Living the LOTUS

Buddhism in Everyday Life

2  
2020

VOL. 173



Үүсгэн байгуулагчийн сургаал

## Цагаан Лянхуа Судрыг хурах

Сэтгэл санаа ариусахад энэ хорвоо тэр чигээрээ “Тэнгэр бурханаар дүүрсэн” ертөнц болон хувирдаг хэмээн “Түүнчлэн Ирсэний Насны Хэмжээ бүлэг”-т бичсэн байдаг. Гэвч бид огт тэгж харж чадалгүй, нийгмийн янз бүрийн бохир зүйлсийг л олж хардаг. Уг нь эргэн тойрныхоо бохирдлыг харахаасаа өмнө өөрийн зүрх сэтгэлийн бохирдлыг арилгахын төлөө хичээх чухал биш гэж үү.

Ничирэн хутагт “Амандаа Цагаан Лянхуа Судрыг уншиж явах юм бол бие доторх бурханлаг чанар хүртэл сэргэж, зайлшгүй ил гарч ирнэ.” хэмээн номлосон. Цагаан Лянхуа Сударт бурхан, бодисадва, тоолж баршгүй олон

хүний хүсэл залбирал шингэсэн байдаг. Тэрхүү судрыг өдөр бүр, өглөө оройд унших үйлийг хийснээр бие сэтгэл аажмаар ариусч, улмаар “хачин хүн” гэж бодож байсан хүнд сайхан сэтгэл нуугдаж байсныг олж харж, түүнийг анзаараагүй явсан өөртөө сэтгэл гутардаг.

Күвана нийгэмлэгийн гишүүн ийм нэгэн илтгэл тавьсан юм. Их Ариун ордны жижүүрийн үйлээр дамжуулж сэтгэл зүрхээ бүхэлд нь угааж ариутгатал Язгуурын бурхан өөр рүү нь инээмсэглэн харж байсан ба “Хөөх, өдийг хүртэл нүд минь булингартаад, Бурханы жинхэнэ дүрийг харж чадахгүй байсан байна. Та бүхний сайхан сэтгэлийг харж чадахгүй байсан

### Living the Lotus Vol. 173 (2020.02)

**Хэвлэсэн:** Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс

**Хаяг:** Fumon Media Center, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537 Japan

**TEL:** +81-3-5341-1124

**FAX:** +81-3-5341-1224

**Email:** [living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp](mailto:living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp)

**Ахлах редактор:** Саитоо Кооичироо

**Орчуулсан:** Ж.Сэлэнгэ, Ж.Гэрэлтуяа

**Эхийг хянасан:** Монголын РКК

Рисшо Косей кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо болон түүний шавь Хамтран үндэслэгч Наганүма Мёокоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Турван Эрдэнийн Цагаан Лянхуа Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулъя гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Гишүүд бид бурхан багшийн шавь болохынхоо хувьд тус байгууллагын Ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд,

*Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд, Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнэтэй амьдралыг туулцаагай гэсэн хүсэл шингэсэн билээ. Бид энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.*

## Амьдралын утга учрыг олъё

Рисшо Косей Кай, Ерөнхийлөгч  
Нивано Ничикоо



### “Та ч бас үхэлтэй тулгарна”

2 дугаар сар бол Бурхан багшийн нирваанд орсон өдрийн ёслол тохиодог сар. Уг ёслол нь Шагжамүни бурханы нас нөгчсөн 2 дугаар сарын 15-ны өдөр болдог ба бурханы олон шавь нар цугларан Бурхан багшийн ач буянд талархаж, сургаал номыг нь гүнзгийрүүлэн суралцдаг өдөр юм. Тэгвэл Шагжамүни бурхан өөрийн “үхэл”-ээр дамжуулж бидэнд юуг дамжуулахыг хүссэн бол?

Миний хувьд “Амьд амьтан бүгд хэзээ нэгэн цагт үхэлтэй тулгарна.” гэсэн үнэнийг сургасан гэж боддог.

Бурханы сургаалд “Төрөх ба үхэх нь нэгэн цогц зүйл” гэж үздэг. Төрөх үхэх хамт оршиж байж л “амьдрал” болдог. Гэтэл бид амьдралын нэг хэсэг болох “үхэл”-ийг огтхон ч хүлээн зөвшөөрдөггүй. Ихэнх хүний хувьд “үхэл” гэдэг аймшигтай бөгөөд тойроод өнгөрмөөр зүйл гэж хэлж болох байх. Тийм ч учраас Шагжамүни бурхан “Та ч бас үхэлтэй тулгарна шүү.” хэмээн энэ ертөнцийн үнэн төрхийг өөрийн биеэр харуулсан юм.

Шагжамүни бурхан өөрийн үхлээр дамжуулж гагцхүү үүнийг л сургах гээгүй байх. Төрсөн бол үхэх, үхсэн бол дахин төрөх гэсэн “Амь нас”-ны том урсгал дунд бид хүн болж энэ ертөнцөд төрсөн ба амьдрахын утга учрыг ч гэсэн сургасан гэж хэлж болно.

Цагаан Лянхуа Судрын Номын багш бүлэгт “Зовж шаналсан хүмүүсийг нигүүлсэн, аз жаргалтай болгохын төлөө хүний ертөнцөд төрсөн.” гэсэн байдаг.

Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан зовлон шаналал нь үл тасрах хүмүүс биднийг аврахын тулд энэ ертөнцөд ирсэн гэсэн үг. Гэхдээ Шагжамүни бурхан ганцаараа ирээгүй нь лавтай. Үүнийг бодож үзэхийн зэрэгцээ хүмүүс бидний амьдралын утга учрын талаар бодоцгооё.





## Амьдрахын утга учир юу вэ

Номын багш бүлэгт “Хамаг амьтныг энэрч нигүүлсэн өөрөө хүсч энэ ертөнцөд төрмүй.” гэж бичсэн байдаг. Зовлон бэрхшээлээр дүүрэн энэ ертөнцөд бид өөрийн хүслээр хүн болж ирсэн гэсэн үг. Нөгөө талаас нь харах юм бол зовлон, жаргал зэрэгцэн оршдог замбуутив гэдгийг мэдсээр байж сонгосон ба бид ертөнцийн жинхэнэ үнэн хийгээд үнэн дүр төрхийг олж харж чадах учраас л одоо энд амьдарч байгаа гэсэн үг болно.

Ойр дотны хүмүүс, гэр бүл эсвэл өөрөө өвдөж, насан эцэслэх нь үнэхээр хүнд хэцүү, харуусалтай зүйл. Гэхдээ тэрхүү бэрхшээл хийгээд харуусал, айдастайгаа нүүр тулснаар жинхэнэ үнэнийг харах нүд тань нээгдэх болно. Зовлон шаналал нь өөрөө авралын үүд болдог гэсэн үг.

Энд өгүүлж буй “Аврал” гэдэг нь хүний амьдралын зовлон бэрхшээлийг амсаж, хичнээн хэцүү байсан ч гэсэн түүгээр дамжуулж амьдралын утга учрыг ухаарч, эрч хүчийг олж авахыг хэлнэ.

Аврагдах, утга учиртай амьдрах гэдгийг хүндээр хүлээж авах хэрэггүй. Энэ нь тухайлбал оройн хоолоо хийхдээ хамаг сэтгэлээ зориулах эсвэл хүнтэй мэндлэхдээ сэтгэлээсээ сайхан мэндчилэх, жижигхэн ч гэсэн өөрийн хийж чадах зүйлээс аз жаргалыг мэдэрч, түүгээрээ бусад хүмүүсийг баярлуулж амьдрах юм. Энэ л амьдралын утга учир, мөн чанар биш гэж үү.

Сэтгэл, мэдрэлийн эмч бөгөөд нацистын хорих лагерт хоригдож байснаараа олонд танигдсан В. Э. Франкл “Хүн төрөлхтөн амьдрахын утга учрыг олох гэж асуулт бий болгох бус, амьдралаас урган гарсан асуултад хариулах ёстой.” гэсэн байдаг. Бид хувь заяа хэмээх яаж ч үл чадах амьдралын сорилт, асуултуудтай нүүр тулж, хүлээн зөвшөөрч, тэр бүхнээс эерэг үнэ цэнэтэй зүйлийг олж харж амьдрах чухал юм.

Үүнийг гэгээрэл, ухаарал ч гэж хэлж болох ба энэ нь өөрөө хүний амьдрал болдог гэж хэлж болох болов уу. Эдогийн үеийн хувраг, зохиолч, яруу найрагч Рёокан “Хорвоо дэлхийн хамгийн зовлонт хүн хэн бэ гэвээс сургаалыг үл мэдэгдч хүн хэмээн хариульюу.” гэсэн байдаг. Тэгвэл хэзээ ч, ямар ч үед утга учиртай амьдрах сургаал номтой учирсан бид нар үнэхээр азтай хүмүүс юм.

«Косей» 2020 оны 2 дугаар сарын дугаар





# Лянхуан Гурамсан Сударын бүлэг тус бүрийн тайлбар

## «Оройн Дээд Цагаан Лянхуа Судар» Судар барихуйг зоригжуулсныг өгүүлэх 13 дугаар бүлэг

Уг бүлгийн эхэн хэсэгт Шагжамүни бурханы өргөж авсан эх болох Махапражпати болон эхнэр Яшодара нарт эш үзүүлсэн тухай гардаг. Өмнө өгүүлсэн Лусын охины үйл явдлаас энэ хүртэлх хэсэг нь “Эмэгтэй хүн бурханы хутаг олох” хэсэг болдог. Гэхдээ энэ хоёр аяга тэхимлиг мэт өндөр боловсролтой, эрдэм чадал төгс, мөн Шагжамүни бурханаас шууд сургаалыг нь сонссон эмэгтэйчүүдэд яагаад хамгийн сүүлд эш үзүүлж,

Манзушири бодисадвагаар дамжуулж сургаал сонссон, өөрөөр хэлбэл номын зээ охин бөгөөд өөр газрын Лусын охинд түрүүлж эш үзүүлэх болов? Үүнд дараах хоёр сургаал агуулагдаж буйг ойлгох хэрэгтэй.

### Цагаан цаас мэт сэтгэлээр сургаалыг байгаагаар нь хүлээж авах

Эхний сургаал нь Ананда, Рахула нартай адилхан. Шагжамүни бурханыг нялх багаас нь асарч өсгөсөн эх, мөн урьд цагт эхнэр нь байж, хүүхэд хүртэл төрүүлж өгсөн хамгийн дотны хүмүүсээ бурханы зам мөрд оруулахын хэцүүг энд өгүүлсэн.

Лусын охин болон Манзушири бодьсадва мэт жирийн багш шавийн харилцаатай бол сургаал номыг тэр дор нь шууд хүлээж авна. Харин багштайгаа машид ойр дотно харилцаатай эх болон эхнэрийнх нь хувьд дотны харилцаа нь садаа болж, эсрэгээрээ сургаалыг шууд хүлээж авч чадахгүй байх нь түгээмэл тохиолддог зүйл.

Үүнийг ойлгуулахын тулд, зориуд сүүлд эш үзүүлсэн гэж ойлгож болно. Тиймээс энэ хоёр аяга тэхимлиг Лусын охиноос дор гэсэн үг огтоос биш юм.

Хоёрдугаарт, “Сургаалыг зөв л түгээн дэлгэрүүлж байвал ямар ч хүн байсан болно. Мөн түүнийг цагаан цайлганаар хүлээн авч л байвал тухайн хүн боловсролтой байна уу үгүй юу хамаагүй. Бүгд адилхан бурханы гэгээрлийг олж чадна.” гэдгийг сургасан. Шагжамүни бурханы өөрийнх нь шавь биш байсан ч, хэдэн мянган жилийн дараа төрсөн хүн байсан ч, мөн ямар ч улс, ямар ч үндэстний хүн байсан хамаагүй.

Хамгийн чухал нь цагаан цаас мэт сэтгэлээр сургаалыг байгаагаар нь хүлээж авснаар

аврагддаг гэсэн үг. Орчин үеийн хүмүүс бидний хувьд машид олзуурхмаар, сайхан сургаал гэж бодож байна.

### Бодьсадвагийн сургаалыг түгээн дэлгэрүүлэх тангараг

“Итгэмжлэн даалгасныг өгүүлэх бүлэг”-ийн гол хэсэг бол дараа нь гарах Цагаан Лянхуа Судрын энэ хүртэлх сургаалыг сонсоод гүн гүнзгий сэтгэл хөдөлж, ялангуяа “Дэвадаттагийн тухай өгүүлэх бүлэг”-т гардаг “Бүх хүн адилхан бурханлаг чанартай.” хэмээх жинхэнэ үнэнийг бодит жишээгээр дамжуулан ойлгож авсан бодьсадва нар энэхүү гайхамшигт сургаалыг амь биеэ зориулан хамгаалж, хэрэгжүүлж, түгээн дэлгэрүүлнэ гэдгээ итгэл төгс тангарагладаг хэсэг юм.

“Судар барихуйг зоригжуулах” гэдэг нь “Судрыг хүлээн авч, сахихыг санал болгох” гэсэн утгатай боловч уг бүлэгт ийм утгатай зүйлийг бараг айлдаагүй бөгөөд эсрэгээрээ бодьсадва нар өөрсдөө түрүүлээд сургаалыг түгээн дэлгэрүүлэх тангараг тавьсан байдаг. Хүнд сургаал номыг санал болгохын тулд эхлээд өөрөө өөртөө хатуу тангараг тавьсан байх ёстой бөгөөд мөн өөрийн биеэр хэрэгжүүлж харуулахгүй л юм бол жинхэнэ утгаараа хүнийг зам мөрд оруулж чадахгүй юм. Энэ утгаараа энэ бүлгийн нэр ч гэсэн маш гүн гүнзгий утгатай болохыг хэлэхгүй өнгөрөх аргагүй.



## Амьдралын утга учир

Бурхан багшийн нирваанд орсон 2-р сар гарлаа. Нивано ерөнхийлөгч энэ сарын сургаалдаа “Шагжамүни будда өөрийн үхлээр дамжуулж амьд бүхэн заавал үхдэг хэмээх үнэнийг сургасан. Түүнчлэн Номын багш бүлгийн “Хүсэж төрөх” сургаалд гардаг шиг хүн болж төрөх учир утгатай” хэмээн айлдсан.

Амьдралын утга учир өөрт оногдсон үүргийг ухамсарлаж, түүнийг чадах чинээгээрээ биелүүлж, эргэн тойрныхоо хүмүүсийг баярлуулахад оршино.

Нэгэн бага ангийн сурагч “Мөрөөдлийн уут” сайн дурын үйл ажиллагаанд оролцсон юм. Тэр хүүгийн өрөөсөн нүд хиймэл ба хиймэл нүд удаан хугацаагаар зүүхээр нөгөө нүдэнд нь ачаалал их ирж зовиуртай байдаг гэж байв. Гэхдээ дайнаас болж эцэг эхээсээ өнчирсөн хүүхдүүдэд “мөрөөдлийн уут” бэлэг тараах хугацаанд хиймэл нүдээ ганц ч удаа авалгүй үйл ажиллагаанд оролцсон юм. Яг одоо миний хийж чадах зүйл энэ л байна хэмээн хичээсэн тэр хүү үнэхээр мундаг байсан.


Өөрчилж болшгүй хувь тавиланг хүлээн авч, өөдрөг амьдрах аргыг тэр хүүгээс суралцсан юм.

РКК, Олон улсын хэлтсийн дарга  
Саитоо Коичи





# Rissho Kosei-kai: A Global Buddhist Movement



## Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii

2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, USA

TEL: 1-808-455-3212 FAX: 1-808-455-4633

Email: [info@rkhawaii.org](mailto:info@rkhawaii.org) URL: <http://www.rkhawaii.org>

## Rissho Kosei-kai Maui Dharma Center

1817 Nani Street, Wailuku, HI 96793, USA

TEL: 1-808-242-6175 FAX: 1-808-244-4625

## Rissho Kosei-kai Kona Dharma Center

73-4592 Mamalahoa Highway, Kailua-Kona, HI 96740, USA

TEL: 1-808-325-0015 FAX: 1-808-333-5537

## Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

2707 East First Street, Los Angeles, CA 90033, USA

POBox 33636, CA 90033, USA

TEL: 1-323-269-4741 FAX: 1-323-269-4567

Email: [rk-la@sbcglobal.net](mailto:rk-la@sbcglobal.net) URL: <http://www.rkina.org/losangeles.html>

Please contact Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

**Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona**

**Rissho Kosei-kai Buddhist Center of Colorado**

**Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego**

**Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas**

**Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas**

## Rissho Kosei-kai of San Francisco

1031 Valencia Way, Pacifica, CA 94044, USA

POBox 778, Pacifica, CA 94044, USA

TEL: 1-650-359-6951 FAX: 1-650-359-6437

Email: [info@rksf.org](mailto:info@rksf.org) URL: <http://www.rksf.org>

Please contact Rissho Kosei-kai of San Francisco

**Rissho Kosei-kai of Sacramento**

**Rissho Kosei-kai of San Jose**

## Rissho Kosei-kai of New York

320 East 39th Street, New York, NY 10016, USA

TEL: 1-212-867-5677 Email: [rkny39@gmail.com](mailto:rkny39@gmail.com) URL: <http://rk-ny.org>

## Rissho Kosei-kai of Chicago

1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056, USA

TEL: 1-773-842-5654

Email: [murakami4838@aol.com](mailto:murakami4838@aol.com) URL: <http://rkchi.org>

## Rissho Kosei-kai of Fort Myers

URL: <http://www.rkftmyersbuddhism.org>

## Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma

2745 N.W. 40th St., Oklahoma City, OK 73112, USA

POBox 57138, Oklahoma City, OK 73157, USA

TEL: 1-405-943-5030 FAX: 1-405-943-5303

Email: [rkokdc@gmail.com](mailto:rkokdc@gmail.com) URL: <http://www.rkok-dharmacenter.org>

## Rissho Kosei-kai Dharma Center of Denver

1255 Galapago St. #809 Denver, CO 80204, USA

TEL: 1-303-446-0792

## Rissho Kosei-kai Dharma Center of Dayton

617 Kling Drive, Dayton, OH 45419, USA

URL: <http://www.rkina-dayton.com>

## The Buddhist Center Rissho Kosei-kai International of North America (RKINA)

2707 East First St., Suite #1, Los Angeles, CA 90033, USA

TEL: 1-323-262-4430 FAX: 1-323-262-4437

Email: [info@rkina.org](mailto:info@rkina.org) URL: <http://www.rkina.org>

## Rissho Kosei-kai Buddhist Center of San Antonio

(Address) 6083 Babcock Road, San Antonio, TX 78240, USA

(Mail) POBox 692042, San Antonio, TX 78269, USA

TEL: 1-210-561-7991 FAX: 1-210-696-7745

Email: [dharmasanantonio@gmail.com](mailto:dharmasanantonio@gmail.com)

URL: <http://www.rkina.org/sanantonio.html>

## Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center

28621 Pacific Highway South, Federal Way, WA 98003, USA

TEL: 1-253-945-0024 FAX: 1-253-945-0261

Email: [rkseattlewashington@gmail.com](mailto:rkseattlewashington@gmail.com)

URL: <http://buddhistlearningcenter.org>

## Rissho Kosei-kai of Vancouver

Please contact RKINA

## Rissho Kosei-kai do Brasil

Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP, CEP 04116-060, Brasil

TEL: 55-11-5549-4446, 55-11-5573-8377

Email: [risho@rkk.org.br](mailto:risho@rkk.org.br) URL: <http://www.rkk.org.br>

Facebook: <https://www.facebook.com/rishokosseikaidobrasil>  
Instagram: <https://www.instagram.com/rkkbrasil>

### **Risho Kosei-kai de Mogi das Cruzes**

Av. Ipiranga 1575-Ap 1, Mogi das Cruzes-SP, CEP 08730-000, Brasil

### **在家佛教韓國立正佼成會**

〒 04420 大韓民國 SEOUL 特別市龍山區漢南大路 8 路 6-3  
6-3, 8 gil Hannamdaero Yongsan gu, Seoul, 04420, Republic of Korea  
TEL: 82-2-796-5571 FAX: 82-2-796-1696

### **在家佛教韓國立正佼成會釜山支部**

〒 48460 大韓民國釜山廣域市南區水營路 174, 3F  
3F, 174 Suyoung ro, Nam gu, Busan, 48460, Republic of Korea  
TEL: 82-51-643-5571 FAX: 82-51-643-5572

### **社團法人在家佛教立正佼成會**

台灣台北市中正區衡陽路 10 號富群資訊大廈 4 樓  
4F, No. 10, Hengyang Road, Jhongheng District, Taipei City 100, Taiwan  
TEL: 886-2-2381-1632, 886-2-2381-1633 FAX: 886-2-2331-3433

### **台南市在家佛教立正佼成會**

台灣台南市崇明 23 街 45 號  
No. 45, Chongming 23rd Street, East District, Tainan City 701, Taiwan  
TEL: 886-6-289-1478 FAX: 886-6-289-1488  
Email: koseikaitainan@gmail.com

### **Rissho Kosei-kai South Asia Division**

Thai Rissho Friendship Foundation  
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang, Bangkok 10310, Thailand  
TEL: 66-2-716-8216 FAX: 66-2-716-8218

### **Rissho Kosei-kai of Kathmandu**

Ward No. 3, Jhamsikhel, Sanepa-1, Lalitpur, Kathmandu, Nepal

### **Rissho Kosei-kai of Kolkata**

E-243 B. P. Township, P. O. Panchasayar, Kolkata 700094, India

### **Rissho Kosei-kai of Kolkata North**

AE/D/12 Arjunpur East, Teghoria, Kolkata 700059, West Bengal, India

### **Rissho Kosei-kai of Bodhgaya Dharma Center**

Ambedkar Nagar, West Police Line Road, Rumpur, Gaya-823001, Bihar, India

### **Rissho Kosei-kai of Patna Dharma Center**

### **Rissho Kosei-kai of Central Delhi**

77 Basement D.D.A. Site No. 1, New Rajinder Nagar, New Delhi 110060, India

### **Rissho Kosei-kai of Singapore**

### **Rissho Kosei-kai of Phnom Penh**

W.C. 73, Toul Sampaov Village, Sangkat Toul Sangke, Khan Reouseykeo, Phnom Penh, Cambodia

### **RKISA Rissho Kosei-kai International of South Asia**

Thai Rissho Friendship Foundation  
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang, Bangkok 10310, Thailand  
TEL: 66-2-716-8141 FAX: 66-2-716-8218

### **Rissho Kosei-kai of Bangkok**

Thai Rissho Friendship Foundation  
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang, Bangkok 10310, Thailand  
TEL: 66-2-716-8216 FAX: 66-2-716-8218 Email: info.thairissho@gmail.com

### **Rissho Kosei Dhamma Foundation**

No. 628-A, Station Road, Hunupitiya, Wattala, Sri Lanka  
TEL: 94-11-2982406 FAX: 94-11-2982405

### **Rissho Kosei-kai of Polonnaruwa**

### **Rissho Kosei-kai Bangladesh**

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh  
TEL/FAX: 880-31-626575

### **Rissho Kosei-kai Mayani**

Mayani Barua Para, Mirsarai, Chittagong, Bangladesh

### **Rissho Kosei-kai Damdama**

Damdama Barua Para, Mirsarai, Chittagong, Bangladesh

### **Rissho Kosei-kai Patiya**

China Clinic, Patiya Sadar, Patiya, Chittagong, Bangladesh

### **Rissho Kosei-kai Satbaria**

Village: Satbaria Bepari Para, Chandanaih, Chittagong, Bangladesh

### **Rissho Kosei-kai Chendhirpuni,**

Village: Chendhirpuni, P.O.: Adhunagar, P.S.: Lohagara, Chittagong, Bangladesh

### **Rissho Kosei-kai Dhaka**

408/8 DOSH, Road No 7 (West), Baridhara, Dhaka, Bangladesh

### **Rissho Kosei-kai Laksham**

Village: Dhupchor, Laksham, Comilla, Bangladesh

### **Rissho Kosei-kai Cox's Bazar**

Ume Burmize Market, Tekpara, Sadar, Cox's Bazar, Bangladesh

### **Rissho Kosei-kai Cox's Bazar, Ramu Shibu**

### **Rissho Kosei-kai Raozan**

Dakkhin Para, Ramzan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

### **Buddiyskiy khram "Lotos"**

4 Gruzinski Alley, Yuzhno-Sakhalinsk 693005, Russia  
TEL: 7-4242-77-05-14

### **Rissho Kosei-kai of Hong Kong**

Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road, North Point, Hong Kong, China

### **Rissho Kosei-kai Friends in Shanghai**

### **Rissho Kosei-kai of Ulaanbaatar**

(Address) 15F Express Tower, Peace avenue, khoro-1, Chingeltei district, Ulaanbaatar 15160, Mongolia

(Mail) POBox 1364, Ulaanbaatar-15160, Mongolia

TEL: 976-70006960 Email: rkkmongolia@yahoo.co.jp

### **Rissho Kosei-kai of Erdenet**

2F Ikh Mandal building, Khurenbulag bag, Bayan-Undur sum, Orkhon province, Mongolia

### **Rissho Kosei-kai di Roma**

Via Torino, 29, 00184 Roma, Italia  
TEL/FAX: 39-06-48913949 Email: roma@rk-euro.org

### **Rissho Kosei-kai of the UK**

### **Rissho Kosei-kai of Paris**

### **Rissho Kosei-kai of Venezia**

### **Rissho Kosei-kai International Buddhist Congregation (IBC )**

166-8537 東京都杉並区和田 2-7-1 普門メディアセンター 3F  
Fumon Media Center 3F, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537, Japan  
TEL: 03-5341-1230 FAX: 03-5341-1224 URL: <http://www.ibt-rk.org>